

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.БАТ-ЭРДЭНЭ

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.5.1.4-т “Газрын доорх цэнгэг усны томоохон ордууд, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах, цэвэр усны нөөц бүхий томоохон нуурын сав газарт аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах замаар усны нөөцийг хамгаална” гэж, 3.5.2.3-т “Бэлчээрийн нөөц газар, Мэнэнгийн тал, говийн баянбүрд, заган ойг улсын тусгай хамгаалалтад авч тал хээрийн эмзэг бүс нутгийн хөрс, ургамал өөрөө нөхөн төлжих боломжийг бий болгох, хөрсний үржил шим, чийгийг хамгаалах нөөц бололцоо бүрдүүлнэ” гэж, түүнчлэн 3.5.3.5-т “Нэн ховор, ховор болон экосистемд онцгой үүрэгтэй амьтан, ургамал бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, тэдгээрийн амьдрах орчныг тэтгэхэд биотехникийн аргыг түлхүү хэрэглэнэ. Нэн ховор, ховор амьтан, ургамал болон бичил биетний омог, эд, эсийн өсгөврийн сан байгуулна” гэж тус тус заажээ.

“Алсын хараа-2050”² Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 6.1-д “I үе шат (2021-2030) Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаална” гэж, “II үе шат (2031-2040) Онцлог, үнэ цэнэ бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авч, анхдагч байгалийн унаган төрх, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална” гэж, “III үе шат (2041-2050) Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн эх дэлхийн экосистемийн үйлчилгээг тэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.” гэж, “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь” хэсэгт 2030 он гэхэд 30 хувийг, 2050 он гэхэд 35 хувь хүргэнэ гэж тус тус заасан байна.

¹Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт.

²Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлого, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”³-ийн 3.4.1.1-д “Байгалийн унаган төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулна” гэж, 3.4.1.2-т “Биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоож, генетик нөөцийг нэмэгдүүлэн тогтвортой ашиглаж, байгалийн нөөцийг хамгаалж, экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоон био аюулгүй байдлыг хангана.” гэж, 3.4.1.3-т “Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”⁴-д “Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн арга зүйгээр хийж, судалгаанд суурилсан байгаль хамгааллын менежмент хөгжих боломжийг бүрдүүлэх, газар нутгийн хамгааллын менежментэд олон талын оролцоонд тулгуурласан хамтын менежментийн зарчмыг нэвтрүүлж, удирдлага зохицуулалт, санхүүжилтийг олон улсын жишигт нийцүүлэх”-ээр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэхээр тусжээ.

1.2.Практик шаардлага

Манай орны байгаль харьцангуй унаган төрхөө хадгалж үлдсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлт болон нийгэм, эдийн засаг, хүний хүчин зүйлээс хамааран цөлжилт, усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөж, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж нэмэгдсэн.⁵ Судалгаагаар нийт газар нутгийн 76.8 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилт, газрын доройтолд өртсөн⁶, үүнээс 22.9 хувийг доройтсон газар нутаг эзэлж байгаа⁷ нь экологийн тэнцэл алдагдах бодит эрсдэлийг дагуулж байна. Хүний үйл ажиллагаа болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр экосистемийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, усны эх үүсвэр, булаг, шанд ширгэх, бэлчээр доройтох, цөлжилт, газрын доройтол нэмэгдэх, амьтан, ургамлын төрөл зүйл, тоо толгой буурах зэрэг сөрөг үр дагавар улам бүр нэмэгдсээр байна. Иймд экологийн хувьд чухал ач холбогдол бүхий газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, экосистемийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, ховор болон нэн ховор амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилт, газрын доройтлыг сааруулах, нөхөн сэргээх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдах боллоо.

³Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

⁴Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралт.

⁵Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт, IRIM Консалтант “Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг, хандлага, дадал болон мэдээллийн судалгаа”, 2023 он, Нөхцөл байдал, VII.

⁶Монгол Улсын Засгийн газар, Алсын хараа - 2050, Урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, 71 дэх тал.

⁷Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-гийн зургаа. Ногоон хөгжил - Газрын доройтлын хувь.

1994 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль батлагдсанаас хойш 17 удаа, харин 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль батлагдсанаас хойш 29 жилийн хугацаанд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Гэвч эдгээр нэмэлт, өөрчлөлт нь ихэвчлэн бусад хууль тогтоомжийн өөрчлөлтийг дагалдсан хэлбэртэй байсан бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь авч үзэн, түүнийг шинэчлэхэд чиглээгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд хамгаалалтын зорилго болон үндсэн суурь харилцааг тодорхойлсон боловч тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн 4 ангиллын бүсчлэл, тэдгээрийн дэглэмийн ялгаа тодорхой бус, тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлт, тусгай хамгаалалттай газрын сүлжээ, бүртгэл, мэдээллийн тогтолцоог хуульчлаагүй, хил орчмын болон хот, тосгон, суурьшлын бүсийн нутаг дэвсгэртэй давхцаж байгаа тусгай хамгаалалттай газрын дэглэм, менежмент тодорхойгүй, менежментийн тогтолцоо, санхүүжилтийн механизм, холбогдох талуудын оролцоо, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрэн тусгаагүй байна. Мөн орчны бүсийн харилцааг тусгайлсан хуулиар салангид байдлаар зохицуулж байгаа нь хууль тогтоомжийн уялдаа холбоог сулруулж, хуулийн хэрэгжилт болон хууль хэрэглээнд хүндрэл үүсгэж байна.

Монгол Улс 2024 онд 810 мянган жуулчин хүлээн авч 1.6 тэрбум ам.долларын орлого олсон нь сүүлийн 70 жилийн түүхэнд байгаагүй хамгийн өндөр үзүүлэлт болж байна.⁸ Жуулчдын очих газрын 80 хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт байгаа⁹ нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тусгай хамгаалалттай газар нутаг чухал ач холбогдолтой болохыг дээрх тоо баримт илтгэж байгаа хэдий ч тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагаа тодорхой зохицуулалтгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт хамгааллын дэглэм түлхүү үйлчилж байгаа тул нөхөн сэргээлт хийх, түймрийн зурвас байгуулах зэрэг шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байгаа тул ойд доройтол, хөгшрөлт ихээр явагдаж, хөнөөлт организм, түймэрт өртөх эрсдэл өндөр байна. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь байгалийн нөөц, ойн дагалт баялгийн даац, нөөцийг тогтоохгүй, зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаагаас улбаалан тухайн бүс нутаг дахь амьтан ургамлын амьдрах орчны зүй тогтлыг алдагдуулж ой модыг гэмтээх, байгалийн нөөцийг зохисгүй ашиглах зэргээр экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахад шууд нөлөө үзүүлж байна.

Зарим тусгай хамгаалалттай газарт нутгийн малчид өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар болон ойн дагалт баялаг, байгалийн ургамал, модыг ахуйн зорилгоор ашиглах боломж хязгаарлагдмал байгааг өөрчлөх шаардлагатай байна.

⁸Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2025 оны 02-р сарын 10-ны өдрийн тоон мэдээлэл.

⁹Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь (SPACES) төсөл", "Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд зориулсан гарын авлага", 2022 он, 23 дахь тал.

Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийг зөвхөн улсын нэгдсэн төсвөөс санхүүжүүлдэг бөгөөд санхүүжилтийн 90 хувь нь хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдын цалин, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалт зэрэг урсгал зардалд зарцуулагддаг байна. Өөрөөр хэлбэл, тусгай хамгаалалттай газар нутагт менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх санхүүгийн боломж хязгаарлагдмал байна. Улмаар санхүүгийн хязгаарлагдмал байдал нь тусгай хамгаалалттай газар нутаг доройтох, алдагдах эрсдэлийг бий болгож байгаа нь энэ төрлийн харилцаанд шинэчлэл хийх чухал нөхцөл болж байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгааллын үйл ажиллагааг улсын хэмжээнд нийт 42 хамгаалалтын захиргаа хариуцан хэрэгжүүлж байгаагаас 7 байгууллага (төрийн бус байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд зэрэг) гэрээний үндсэн дээр менежментийг хариуцан хэрэгжүүлдэг. Эдгээр байгууллага нь үйл ажиллагааны зардлаа орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудын хандив, тусламжийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна. Тусгай хамгаалалттай газар нутагт хамгааллын чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, байгаль хамгааллын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр, тэдгээрийн үйл ажиллагаа, үр дүнд хяналт тавих зэрэг харилцааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд нутгийн иргэд, нутгийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь өргөн уудам нутаг дэвсгэрт хяналт тавих, зөвшөөрөгдсөн бүсэд байгалийн нөөцийг судалгаа, шинжилгээнд үндэслэн зохистой ашиглах, хамгааллын арга хэмжээг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна.

Газар, геологи, уул уурхай, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай мэдээлэл солилцох, газрын кадастр, мэдээллийн системүүдийг уялдуулах, тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой бүртгэл, зөвшөөрөл, хяналт, мэдээллийг цахимжуулахтай холбогдсон эрх зүйн орчин дутагдалтай байгааг засан сайжруулах шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагын дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзлээ.

Хоёр: Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Ийнхүү тус хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос шалтгаалан хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төрлөөр боловсруулав.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 9 бүлэг 57 зүйлтэй байх бөгөөд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд:

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бий болгож, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгаас гадна олон улсын байгаль

хамгааллын зорилго бүхий ангилалд орсон ойн болон усны хамгаалалтын бүсийн газар нутгийг бүртгэж, олон улсын сүлжээгээр мэдээлэл солилцох, олон улсын холбогдох байгууллагад бүртгүүлэх нөхцөлийг бий болгоно.

2.Газар нутгийг тусгай хамгаалалтад авах шалгуур үзүүлэлтийг ангилал тус бүрээр нарийвчлан тодорхойлсноос гадна тусгай хамгаалалттай газар нутгийн дотоод болон орчны бүсийг тодорхойлж, бүс тус бүрийн хамгаалалтын дэглэм, горимыг тодорхой болгон, хориглох үйл ажиллагааг ялгамжтай тодорхойлох бөгөөд дотоод бүсийг өөрчлөх болон газар нутгийг тусгай хамгаалалтад авах журмыг тухайлан заана.

3.Тусгай хамгаалалттай газар нутгийн иргэдийн оролцоо, эрх, уламжлалт ахуйн хэрэглээг хамгаалалтын дэглэмтэй уялдуулна. Тухайлбал, уламжлалт мал аж ахуй үе дамжин эрхэлж ирсэн малчин өрхөд өвөлжөө, хаваржааны доорх газрыг ашиглуулах, уламжлалт мал аж ахуй эрхлэх, хадлан бэлтгэх, ахуйн хэрэглээнд түлээ, шургааг, ойн дагалт баялаг, байгалийн ургамлыг ахуйн хэрэглээнд ашиглах, нутгийн иргэдийн оролцоог тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд хангах замаар үр шимийг хүртэх боломжийг нээнэ.

4.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах зохицуулалтыг өөрчилж, зөвшөөрөгдсөн бүсэд зөвхөн байгалийн аялал жуулчлал, малчин өрхөд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газрыг тусгай зөвшөөрөлтэйгээр ашиглуулж болохоор заана. Газар ашиглагчдын эрх, үүрэг, хориглох үйл ажиллагааг тодорхой хуульчилна. Газар ашиглагчтай газар ашиглуулах гэрээ байгуулах, гэрээг сунгах, хүчингүй болгох, дуусгавар болгох, газар чөлөөлөхтэй холбоотой зохицуулалтыг шинээр тусгана.

5.Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал явуулах нөхцөлийг сайжруулж, хамгаалалтын бүсэд хориглодог байсан аялал жуулчлалын үйл ажиллагааг хязгаарлагдмал хэлбэрээр буюу байгалийн аялал жуулчлал явуулах боломжийг бүрдүүлж, аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглуулах зохицуулалтыг ойлгомжтой болгоно. Мөн тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхдээ экологийн даацад үндэслэх, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлагыг хуульчилна.

6.Экосистемд суурилсан менежментийг хэрэгжүүлж, хамгаалахын зэрэгцээ экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлж, хязгаарлалтын бүсэд зохистой ашиглалтыг явуулах боломж бүрдүүлнэ. Тусгай хамгаалалттай газар нутгийн кадастр, мэдээллийн цахим системийг хөгжүүлнэ. Мөн дархан цаазат газраас бусад ангиллын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чиг үүргийг төрийн бус байгууллага, малчин өрхийн анхдагч холбоо, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд гэрээгээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг тодорхой болгоно.

7.Тусгай хамгаалалттай газар нутгийн кадастр, мэдээллийн сангийн зохицуулалтыг шинээр бий болгож, түүнд байрших мэдээллийг тухайлан заана. Мөн төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих талаар тусгана.

8.Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлж, улсын болон орон нутгийн төсвөөс гадна хандив, тусламж болон бусад нэмэлт эх үүсвэрээс бүрдэхээр тусгана. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, мөн санхүүжилт нь суурь зардал болон үр дүнгийн нь санхүүжилтээс бүрдэх, хамгаалалтын захиргаа явуулж болох төлбөртэй үйлчилгээний жагсаалт, төлбөрт

үйлчилгээний тарифыг тогтоох, холбогдох журмын дагуу үйлчилгээний орлогыг зарцуулахаар хуульчилна.

Тусгай хамгаалалттай газар нутагт нүүрстөрөгчийн болон биологийн олон янз байдлын кредитийн төсөл хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, орлогыг хамгаалалт, нөхөн сэргээлт, менежментэд зарцуулахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх саналын талаар

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм, байгаль орчин, хууль зүйн дараах эерэг үр дагавар гарна:

-Монгол орны биологийн олон янз байдал, экосистемийн тэнцвэрт байдал, байгалийн болон түүх, соёлын дурсгалт, үзэсгэлэнт газрын хэв шинж, байгалийн үнэ цэнийг хамгаалах, нүүдлийн соёл, уламжлалыг хадгалах болон байгаль орчны доройтлыг хязгаарлах, нөхөн сэргээх, зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн цогц орчин бүрдэнэ.

-Цэнгэг усны нөөц, урсац, бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг нэмэгдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах, олон талт байгаль хамгааллын менежмент, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

-Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хамгаалалтын дэглэмийг бууруулахгүй байх, түүнийг өргөжүүлэн тэлэх эрх зүйн орчин сайжирна.

-Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд иргэдийн нөхөрлөл, малчин өрхийн анхдагч холбоо, төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил зэрэг талуудын оролцоог хангах эрх зүйн орчин бүрдсэнээр байгаль хамгааллын үйл ажиллагаанд төрийн чиг үүргийн төвлөрлийг сааруулна.

-Тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсэд амьдарч байгаа иргэдийн өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар ашиглах, хадлан, бэлчээр, байгалийн ургамал, ойн дагалт баялгийг ашиглах, аялал жуулчлалын үйл ажиллагаанаас орлого олох, ажлын байрыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

-Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх орлогын нэмэлт эх үүсвэрүүдийг бий болгож, өөрийгөө санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр улсын төсөвт үзүүлэх дарамт буурч, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн тогтолцоо хөгжинө.

-Хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд учирч байсан хүндрэл, бэрхшээл болох хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг

хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---